



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 213

Улаанбаатар хот

“Хөдөө аж ахуйн бирж” хязгаарлагдмал хариуцлагатай
компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл
хэрэгжүүлэх гишүүдийг томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь заалт, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх журам”-ын 2.10, 4.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 01/914 дүгээр албан санал, Авлигатай тэмцэх газрын 2019 оны 05/3078, 05/3849 дүгээр дүгнэлтийг харгалзан “Хөдөө аж ахуйн бирж” хязгаарлагдмал хариуцлагатай компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүнээр Я.Эрдэнэсайхан /Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны газрын дарга/, Я.Алтангэрэл /Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны ахлах мэргэжилтэн/, А.Ариунболд /Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын хэлтсийн дарга/, М.Болор /Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын мэргэжилтэн/ нарыг томилсугай.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



А.АРИУНБОЛД